

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/019/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorloo.ga@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/284
танай _____-ны № _____-т

“ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ОЧИРХУЯГ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, зорилтот түвшний гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар 1,034.0 сая төгрөгийн, аймгийн ИТХ-ын шийдвэрээр 968.0 сая төгрөгийн нийт 2,002.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй болон зориулалт бусаар зарцуулсан 6.5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, хамтын гэрээ, компанийн мөнгөн кассын журмыг шинэчлэн батлуулж дагаж мөрдөх, Төлөөлөн удирдах зөвлөлийн тушаал шийдвэртэй холбоотой 5 зөвлөмжийг хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

“Хөвсгөл Эрчим Хүч”ХХК-ийн гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр бизнес төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	268,769,209.22	69,921,641.85		
1.1.2	Дансны авлага	911,305,212.97	1,681,516,716.22		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	26,188,043.99	453,180,413.94		
1.1.6	Бараа материал	595,363,851.77	660,602,777.47		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,801,626,317.95	2,865,221,549.48		
1.2.1	Үндсэн хөрөнгө	30,529,114,353.27	31,811,426,646.58		
1.2.2	Биет бус хөрөнгө	651,056,535.48	720,193,722.26		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,180,170,888.75	32,531,620,368.84		
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	32,981,797,206.70	35,396,841,918.32		
2.1.1.1	Дансны өглөг	1,938,330,951.79	3,054,832,785.94		
2.1.1.3	Татварын өр	42,469,612.81	103,079,570.23		
2.1.1.4	НДШ-ийн өглөг	114,785.72	0.00		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	26,917,850.05	39,377,340.32		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,007,833,200.37	3,197,289,696.49		
2.1.2.1	Урт хугацаат зээл	680,338,264.46	710,443,041.55		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	680,338,264.46	710,443,041.55		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,688,171,464.83	3,907,732,738.04		
2.3.1	Төрийн өмч	16,800,000,000.00	16,800,000,000.00		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,831,501,384.55	7,831,501,384.55		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	9,996,667,789.93	11,998,706,547.62		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-4,334,543,432.61	-5,141,098,751.89		
2.3.11	Эздийн өмчийн дүн	30,293,625,741.87	31,489,109,180.28		
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	32,981,797,206.70	35,396,841,918.32		

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн		
1	Борлуулалтын орлого (цэвэр)	20,963,830,758.73	26,019,173,877.50		
2	Борлуулалтын өртөг	18,155,346,549.26	23,904,598,996.15		
3	Нийт ашиг (алдагдал)	2,808,484,209.47	2,114,574,881.35		
4	Түрээсийн орлого	1,472,727.30	1,431,818.19		
5	Хүүгийн орлого	875,638.82	1,153,855.23		
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00		
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00		
8	Бусад орлого	417,799,376.48	670,770,992.14		
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,384,294,494.82	2,868,243,390.40		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	208,772,401.73	277,697,019.26		
11	Санхүүгийн зардал	0.00	0.00		
12	Бусад зардал	231,786,798.95	370,419,579.44		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00		

14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	403,778,256.57	-728,428,442.19
19	Орлогын татварын зардал	40,290,261.78	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	363,487,994.79	-728,428,442.19
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	363,487,994.79	-728,428,442.19
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	363,487,994.79	-728,428,442.19
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,732,310,253.97	-4,963,445,077.80	28,400,366,560.72
2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
3 Заглуулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,732,310,253.97	-4,963,445,077.80	28,400,366,560.72
4 Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
5 Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	1,264,357,535.96	0.00	1,264,357,535.96
6 Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
7 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	363,487,994.79	363,487,994.79
8 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	7,831,501,384.55	0.00	0.00	7,831,501,384.55
9 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	9,996,667,789.93	-4,334,543,432.61	30,293,625,741.87
10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-78,126,877.09	-78,126,877.09
11 Заглуулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	9,996,667,789.93	-4,412,670,309.70	30,215,498,864.78
12 Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
13 Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	2,002,038,757.69	0.00	2,002,038,757.69
14 Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
15 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-728,428,442.19	-728,428,442.19
16 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	7,831,501,384.55	0.00	0.00	7,831,501,384.55
17 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	11,998,706,547.62	-5,141,098,751.89	31,489,109,180.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	17,106,455,978.43	22,671,975,844.26	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	17,106,455,978.43	22,671,975,844.26	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	17,062,366,504.08	22,488,082,624.67	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	44,089,474.35	183,893,219.59	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,641,736,367.64	22,704,588,348.68	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,139,860,846.17	2,651,078,567.24	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	944,135,609.00	1,181,772,522.45	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,262,552,263.32	1,208,087,665.90	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,638,397.96	1,030,377.73	
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,916,959,643.47	15,756,353,065.73	
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	5,882,719.44	5,402,497.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	938,989,794.95	1,359,589,085.11	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,941,381.82	10,417,100.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	418,775,711.51	530,857,467.52	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	464,719,610.79	-32,612,504.42	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	875,638.82	1,153,855.23	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00	
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	875,638.82	1,153,855.23	
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	86,718,636.36	119,366,818.18	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	86,718,636.36	119,366,818.18	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-85,842,997.54	-118,212,962.95	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00	
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00	
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	191,332,200.00	48,022,100.00	
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	191,332,200.00	48,022,100.00	
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00	

3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-191,332,200.00	-48,022,100.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	187,544,413.25	-198,847,567.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81,224,795.97	268,769,209.22
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	268,769,209.22	69,921,641.85

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	төлөвлөгөө	Тайлант оны	
			Гүйцэтгэл	Зөрүү /төгрөгөөр/
1	Борлуулалтын орлого	19,435,442,020.00	19,530,108,277.00	(94,666,257.00)
2	Түгээх үйлчилгээний орлого	6,489,065,600.00	6,489,065,600.00	-
3	Бусад орлого	706,558,900.00	673,356,665.00	33,202,235.00
4	Нийт орлого	26,631,066,520.00	26,692,530,542.00	(61,464,022.00)
1	Шатахууны зардал	121,620,200.00	103,103,558.00	18,516,642.00
2	Тээврийн зардал	4,704,500.00	5,550,000.00	(845,500.00)
3	Сэлбэг хэрэгсэл	111,090,000.00	105,919,131.00	5,170,869.00
4	Урсгал засвар	128,912,000.00	121,969,605.00	6,942,395.00
5	Материал, хангамжийн материал	4,305,500.00	4,693,616.00	(388,116.00)
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	4,214,016,000.00	4,212,751,130.00	1,264,870.00
7	Ахмадын сангийн зардал	33,984,000.00	27,989,500.00	5,994,500.00
8	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	615,960,000.00	574,399,297.00	41,560,703.00
9	Ашиглалтын зардал-Цахилгаан	87,196,940.00	90,105,793.00	(2,908,853.00)
10	Ашиглалтын зардал-Дулаан	60,298,800.00	59,008,408.00	1,290,392.00
11	Ашиглалтын зардал-Ус	4,550,000.00	5,480,351.00	(930,351.00)
12	Албан томилолтын зардал	128,261,200.00	101,254,202.00	27,006,998.00
13	Конторын хангамжийн зардал	11,861,200.00	17,672,477.00	(5,811,277.00)
14	Харилцаа холбооны зардал	11,756,300.00	10,737,541.00	1,018,759.00
15	Харуул хамгаалалтын зардал		-	
16	Хөдөлмөр хамгааллын зардал	168,037,300.00	172,394,723.00	(4,357,423.00)
17	Даатгалын зардал	10,457,100.00	10,417,000.00	40,100.00
18	Галын аюулаас хамгаалах зардал	1,076,200.00	1,076,200.00	-
19	Гүйцэтгэх удирдлагын зардал	12,837,900.00	12,508,121.00	329,779.00
20	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	130,454,700.00	125,001,526.00	5,453,174.00
21	Борлуулалт, маркетингийн зардал	31,922,000.00	43,490,595.00	(11,568,595.00)
22	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	28,327,000.00	28,300,000.00	27,000.00
23	Гадны үйлчилгээний хөлс	70,814,490.00	57,501,006.00	13,313,484.00
24	Аваарын нөөцийн зардал	45,222,780.00	1,795,700.00	43,427,080.00
25	Сургалтын зардал	13,840,400.00	11,415,054.00	2,425,346.00
		6,051,506,510.00	5,904,534,544.00	146,971,966.00
26	Элэгдлийн зардал	1,662,497.80	1,897,575.00	(235,077.20)
	Үүнээс: Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	51,237,488.00	55,312,566.00	(4,075,078.00)
	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	1,611,260,310.00	1,842,262,420.00	(231,002,110.00)
27	Орлогын албан татвараас бусад татвар	10,749,500.00	10,390,207.00	359,293.00
	Үүнээс: Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,273,560.00	7,194,063.00	1,079,497.00
	АТӨЯХ-ийн албан татвар	999,100.00	1,255,937.00	(256,837.00)
	Газрын төлбөр	1,476,800.00	1,940,207.00	(463,407.00)
	Бусад татвар хураамж			-

28	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	53,424,597.00	5,402,497.00	48,022,100.00
29	Үйл ажиллагааны бус бусад зардал		-	
30	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		-	
31	Ажиллагсдын нийгмийн зардал	467,016,510.00	455,246,900.00	11,769,610.00
32	Орлогын татварын зардал			-
	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	520,441,109.00	460,649,397.00	59,791,712.00
33	Валютын ханшны алдагдал		-	
	Үйл ажиллагааны зардлын дүн	8,245,194,877.00	8,273,149,134.00	(27,954,257.00)
34	Худалдаж авсан ЦЭХ-ний төлбөр	18,391,165,700.00	18,777,390,271.00	(386,224,571.00)
	Нийт Үндсэн ҮА-ны зардал	26,636,360,577.00	27,050,539,405.00	(414,178,828.00)
	Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн	390,637,900.00	370,419,579.00	20,218,321.00
	НИЙТ ЗАРДАЛ /37+40+43/	27,026,998,477.00	27,420,959,984.00	(393,961,507.00)
38	Нийт ашиг/алдагдал /48-44/	-395,931,957.00	-728,429,442.00	332,497,485.00
39	Орлогын татварын зардал	34,336,000.00	-	
40	Татварын дараах ашиг/алдагдал	-430,267,957.00	-728,428,442.00	298,160,485.00
41	Тайлант үеийн ашиг алдагдал	-430,267,957.00	-728,428,442.00	298,160,485.00

3. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар нийт 78.1 сая төгрөгийн алдааг илрүүлсэн ба аудитын хугацаанд залруулсан. Үүнд:

1. Хөвсгөл Эрчим Хүч ХХК нь Сангийн яаманд төлөх урт хугацаат өр төлбөрийг 78.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг залруулсан.

Аудитаар нийт 203.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6.5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 196.5 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

3.2 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй 2.5 сая төгрөгийн шатахууны зардал санхүүжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Байгууллагын хөрөнгөөр шинэ жилийн баярын арга хэмжээн дээр азтан шалгаруулахад 1.4 сая төгрөг зарцуулж компанийн үр ашгийг бууруулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Байгууллагын хөрөнгөөр 1.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Хөвсгөл эрчим хүч ХХК нь тайлант онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад 1.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3. Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төлөөлөн Удирдах зөвлөлд:

1. Тогтоол шийдвэртэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-өөс бизнес төлөвлөгөөг 395.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллагааг баталсан ба гүйцэтгэлээр 728.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь баталсан хэмжээнээс 45.6 хувиар хэтэрсэн байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-т заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төлөөлөн удирдах зөвлөлөөс бизнес төлөвлөгөөг алдагдалгүй баталж, компанийн үйл ажиллагааг зохистой байдлаар чиглүүлж ажиллах

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч, холбогдох ажилтнуудад:

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

1.1.1 Илрүүлэлт: Хөвсгөл Эрчим Хүч ХХК нь тайлант онд нярвын харилцах дансанд 153.7 сая төгрөг шилжүүлэн касст авч зарцуулсан,кассын үйл ажиллагааны журмыг 2013 оноос хойш өөрчлөөгүй, тус журамд заагдсан зүйл заалтууд зөрчигдсөн байна. Энэ нь Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн НБББББ-ийн 2.1-т "Санхүү бүртгэлийн ажлын чиг үүрэг заалтын Бэлэн мөнгөний нярав нь бэлэн мөнгө хүлээн авах, хадгалах, зарцуулах, үйл ажиллагааг явуулна. "Компанийн захирлын тушаалаар баталсан мөнгөн кассын журам"-ыг мөрдөнө" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Компанийн мөнгөн кассын журмыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллах ба нярвын хувийн харилцах дансаар байгууллагын мөнгийг дамжуулан зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох

2.2.1 Илрүүлэлт: Хөвсгөл Эрчим Хүч ХХК нь 2025 оны шилдгийн шилдэг, шилдэг ажилтан болон бусад шагнал авсан 13 албан хаагчдад 17.0 сая төгрөг, 4 албан хаагчдад ТУЗ-ийн нэрэмжит шагнал 2.0 сая төгрөг нийт 19.0 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг хавтгайруулан олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шагнал, урамшууллыг хавтгайруулан олгохгүй байх,

2.3.1 Илрүүлэлт: Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн халаалтын улирлын хөнгөлөлтийг хамтын гэрээнд зааснаас 23.7 сая төгрөгөөр илүү олгон компанийн үр ашигийг бууруулсан байна. Энэ нь тус компанийн хамтын гэрээний 5.4 "халаалтын улирлын хөнгөлөлтийг нийт ажилтанд жилд 100,000.00/нэг зуу/ мянган төгрөгөөр бодож олгоно. Нэг байгууллагад нэг гэр бүлийн хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно. /энэ заалт ахмадуудад болон ҮО болон МШӨ-ий групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд нэгэн адил хамаарах болно/" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3.2 Өгсөн зөвлөмж: Хамтын гэрээг хуульд тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах

3. Өр авлагатай холбоотой

3.1.1 Илрүүлэлт: Хөвсгөл Эрчим Хүч ХХК нь тайлант онд 3,197.3 сая төгрөгийн дансны өр, 2,134.7 сая төгрөгийн авлага тайлагнасан байгаа ба өмнөх оны санхүүгийн тайланд тугагдсан өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх; гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын хөрөнгийг зохистой удирдаж, үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Урт хугацаат Өр төлбөрийн үлдэгдлийг буруу тайлагнасан	1	78,126.9			1	78,126.9	1	78,126.9		
Дүн	1	78,126.9			1	78,126.9	1	78,126.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Харилцах данснаас касст бэлэн мөнгө авахдаа нярвын дансанд шилжүүлэн авсан	1	153,734.0					1	153,734.0				
Анхан шатны баримтгүй	1	2,500.0	1	2,500.0								
Шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон	1	19,034.4					1	19,034.4				
Халаалтын улирлын хөнгөлөлтийг хамтын гэрээнд заасан дүнгээр биш ЭХЗХ-ы батлагдсанаар олгосон	1	23,700.0					1	23,700.0				
Өмнөх оны авлага, өр төлбөрийг барагдуулалгүй, нэмэгдүүлсэн	1	0					1	0				
	5	198,968.4	1	2,500.0			4	196,468.4	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн.	2	2,545.0	2	2,545.0				
ТУЗ-ийн тогтоол шийдвэртэй холбоотой	2	1,500.0	1	1500.0			1	0.0
Дүн	4	4,045.0	3	4,045.0			1	0.0